



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/НЧН

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын Хилийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4 дахь заалт, 4.1 дэх заалт, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 18 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эрдэнэ сумд байрлах Хилийн цэргийн 0166 ангийн "Замын билгэх" салбар, 0214 дүгээр ангийн "Өргөстэй" салбаруудын үйл ажиллагаанд шаардагдах явуулын старлинк төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 10,000,000 /арван сая/ төгрөгийг Улсын Онцгой комиссын зудын гамшигт зарцуулах хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Ш.Эрдэнэбат/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Мягмарсүрэн)-д, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т тус тус даалгасугай.



ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

